



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалт, Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021, 2023 оны 110/ШШ2021/0074, 110/ШШ2023/0033 дугаар шийдвэр, Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2023 оны “Шүүхийн шийдвэрийн дагуу эзэмшил газрын хэмжээнд өөрчлөлт оруулах, шинээр газар эзэмшүүлэх тухай” А/736, 921 захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн Гаалийн газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэгж талбарын 10166 метр квадрат талбай бүхий, нийт 121,992,000.00 (нэг зуун хорин нэгэн сая есөн зуун ерэн хоёр мянга) төгрөгийн балансын үнэтэй “газар эзэмших эрх”-ээс хавсралтад заасны дагуу 397 метр квадрат талбай бүхий нийт 4,764,000.00 (дөрвөн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга) төгрөгийн балансын үнэтэй газар эзэмших эрхийг данснаас хасч залруулга хийхийг зөвшөөрсүгэй.

2.Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, Баян-Өлгий аймгийн Гаалийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чухалбуян нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Газар эзэмших эрхийг шинэчлэн баталгаажуулж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001257
9-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн
135 дугаар тогтоолын хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ГААЛИЙН ГАЗРЫН БИЕТ БУС ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Нэгж талбарын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Данснаас хасах метр квадрат	Данснаас хасах үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх (Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, Э-0213005945 дугаартай	8312021965	м.кв	1864	22,368,000.00	186	2,232,000.00
2	Газар эзэмших эрх (Төрийн захиргааны байгууллагын зориулалттай, Э-0213005942 дугаартай	8312021966	м.кв	8302	99,624,000.00	211	2,232,000.00
Нийт дүн				10166	121,992,000.00	397	4,464,000.00
					(нэг зуун хорин нэгэн сая есөн зуун ерэн хоёр мянга)		(дөрвөн сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга)